

# БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/114/НА- СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор хот

2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын

Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)

Аудитын менежер М.Алтантуяа

Утас: 70442424 Цахим хаяг: [altantuyam@audit.gov.mn](mailto:altantuyam@audit.gov.mn)

Ахлах аудитор Б.Должмаа

Утас: 88110538 Цахим хаяг: [doljmaab@audit.gov.mn](mailto:doljmaab@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал .....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	18
5.1 Төлбөрийн акт .....	19
5.2 Албан шаардлага .....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	20

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХХААЯ	Хүнс, хөдөө аж ахуйн яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ЖДҮХС	Жижиг, дунд үйлдвэрийн хөгжүүлэх сан
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement\_bayankhongor@audit.gov.mn

2025.02.20 № 2/18  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 70803 (Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх), 70805 (Хөдөө аж ахуй, газар тариалангийн бодлого) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс баталсан 1,005,253.1 мянган төгрөгийн санхүүжилтээс 11,236.1 мянган төгрөгийг дутуу буюу 994,017.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, оны эцэст зардлын хэмнэлтийн 35,115.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тус байгууллагад 20 нэр төрлийн тоног төхөөрөмж ирснийг хүлээн авсан боловч эрх бүхий байгууллагын шийдвэр гараагүйгээс тайлант оны бүртгэлд тусгаагүй байна.

5020180

### **Бусад асуудлын хэсэг**

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар 2024 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 3 зорилтын 36 арга хэмжээний хэрэгжилтийг 96.4 хувиар үнэлсэн бөгөөд эрх бүхий дээд байгууллага дүгнээгүй байна.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2024 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ





## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>281,534,828.26</u></b>	<b><u>298,191,833.73</u></b>
33	<b>АВЛАГА</b>	2,827,000.00	99,161.00
335	<b>Бусад авлага</b>	2,827,000.00	99,161.00
33510	Байгууллагаас авах авлага	-	99,161.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	2,827,000.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	278,707,828.26	298,092,672.73
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	162,073,416.96	177,444,123.26
35110	Тусгай зориулалттай материал	162,073,416.96	177,444,123.26
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	116,634,411.30	120,648,549.47
35410	Бичиг хэргийн материал	4,722,596.00	4,071,346.00
35420	Аж ахуйн материал	30,919,079.00	31,461,181.00
35430	Сэлбэг хэрэгсэл	115,000.00	115,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,057,510.30	1,722,299.20
35450	Барилгын засварын материал	244,425.00	244,425.00
35470	Бусад хангамжийн материал	79,575,801.00	83,034,298.27
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>620,874,672.60</u></b>	<b><u>1,385,356,734.99</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	620,874,672.60	1,385,356,734.99
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	566,484,672.48	804,817,934.83
39201	Барилга, байгууламж, орон сууц	381,450,950.00	381,450,950.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(72,399,551.63)	(88,663,877.99)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	212,010,527.00	554,677,196.05
39204	Хуримтлагдсан элэгдэл	(133,013,651.48)	(267,806,044.69)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	144,429,847.51	195,750,229.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	(99,998,036.66)	(124,633,443.33)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,833,216.85	92,875,077.37
39208	Хуримтлагдсан элэгдэл	(24,551,122.81)	(49,382,133.41)
39214	Бусад үндсэн хөрөнгө	151,146,193.78	151,146,193.78
39215	Хуримтлагдсан элэгдэл	(24,423,700.08)	(40,596,212.28)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	54,390,000.12	580,538,800.16
39301	Програм хангамж	7,780,000.00	7,780,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(7,039,999.88)	(7,559,999.84)
39303	Бусад биет бус хөрөнгө	53,650,000.00	580,318,800.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>902,409,500.86</u></b>	<b><u>1,683,548,568.72</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>902,409,500.86</u></b>	<b><u>1,683,548,568.72</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	902,409,500.86	1,683,548,568.72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	(118,275,000.00)	(118,275,000.00)
51101	Өмч: - төрийн	(118,275,000.00)	(118,275,000.00)
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	485,962,028.11	1,267,101,095.97
51210	Өмнөх үеийн үр дүн	164,314,044.68	485,962,028.11
51220	Тайлант үеийн үр дүн	321,647,983.43	781,139,067.87
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	85,813,397.90	85,813,397.90
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>902,409,500.86</u></b>	<b><u>1,683,548,568.72</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,340,438,351.70</b>	<b>2,176,345,077.95</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>555,741,916.70</b>	<b>1,104,934,209.95</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	555,741,916.70	1,104,934,209.95
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,000.00	11,650,885.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	11,300,885.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	350,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	203,817,764.70	833,341,304.95
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	351,889,152.00	259,942,019.99
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>784,696,435.00</b>	<b>1,071,410,868.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	676,016,000.00	994,017,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	676,016,000.00	994,017,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	108,680,435.00	77,393,868.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	26,200,000.00	-
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	18,279,997.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	54,500,000.00	74,071,508.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,042,976.00	2,522,360.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,657,462.00	800,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,018,605,868.27</b>	<b>1,199,705,911.08</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,018,605,868.27</b>	<b>1,199,705,911.08</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	992,087,737.56	1,058,449,363.77
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	424,782,942.66	601,243,539.00
210101	Үндсэн цалин	291,173,252.13	393,743,430.00
210102	Нэмэгдэл	90,178,224.73	156,711,869.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,402,009.00	26,859,000.00
210104	Урамшуулал	32,029,456.80	23,929,240.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	53,044,079.11	75,329,596.00
210201	Тэтгэврийн даатгал	36,109,967.06	51,114,722.88
210202	Тэтгэмжийн даатгал	4,250,125.93	6,025,635.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,400,220.75	3,125,144.80
210204	Ажилгүйдлийн даатгал	844,030.92	3,012,818.29
210205	Эрүүл мэндийн даатгал	8,439,734.45	12,051,274.64
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	13,300,962.21	26,052,584.69
210301	Гэрэл, цахилгаан	2,022,476.00	5,154,593.45
210302	Түлш, халаалт	9,133,696.21	18,875,291.24
210303	Цэвэр, бохир ус	2,144,790.00	2,022,700.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	80,798,820.14	40,561,196.10
210401	Бичиг хэрэг	4,377,350.00	7,904,500.00
210402	Тээвэр, шатахуун	29,889,523.83	20,523,571.10
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,303,620.31	2,509,530.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	116,792.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,026,340.00	9,506,803.00
210408	Бараа материал акталсны зардал	17,601,986.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,521,190.00	1,060,000.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	800,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	4,721,190.00	60,000.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>7,216,300.00</b>	<b>13,960,700.00</b>
210702	Дотоод албан томиллолт	7,216,300.00	13,960,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>146,657,827.00</b>	<b>126,270,998.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	139,773,500.00	119,857,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	247,100.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	604,792.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,784,000.00	6,054,000.00
210807	Газрын төлбөр	1,238,435.00	359,798.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>260,765,616.44</b>	<b>173,970,749.98</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	202,981,984.50	95,673,507.42
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	57,783,631.94	78,297,242.56
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>26,518,130.71</b>	<b>141,256,547.31</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,450,000.00</b>	<b>91,662,606.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	5,400,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	84,612,606.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,450,000.00	1,650,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>25,068,130.71</b>	<b>49,593,941.31</b>
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	6,657,462.00	11,301,382.00
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	18,410,668.71	38,292,559.31
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>321,832,483.43</b>	<b>976,639,166.87</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>184,500.00</b>	<b>195,500,099.00</b>
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	184,500.00	195,500,099.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(184,500.00)</b>	<b>(195,500,099.00)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>321,647,983.43</b>	<b>781,139,067.87</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>784,731,435.00</b>	<b>1,085,888,753.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>35,000.00</b>	<b>3,177,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>35,000.00</b>	<b>3,177,000.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,000.00	3,177,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	3,177,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>784,696,435.00</b>	<b>1,082,711,753.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>676,016,000.00</b>	<b>994,017,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	676,016,000.00	994,017,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>108,680,435.00</b>	<b>88,694,753.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	26,200,000.00	-
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	18,279,997.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	54,500,000.00	74,071,508.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,042,976.00	2,522,360.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,657,462.00	12,100,885.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>772,968,435.00</b>	<b>1,076,460,753.00</b>

21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>772,968,435.00</b>	<b>1,076,460,753.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>746,450,304.29</b>	<b>935,204,205.69</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	424,836,356.92	590,894,345.00
210101	Үндсэн цалин	282,902,877.99	362,538,720.00
210102	Нэмэгдэл	99,646,964.73	170,164,331.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,402,004.40	30,420,262.00
210104	Урамшуулал	30,884,509.80	27,771,032.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	52,990,664.85	85,757,951.00
210201	Тэтгэврийн даатгал	36,056,552.69	54,900,304.50
210202	Тэтгэмжийн даатгал	4,250,125.93	14,578,775.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,400,220.75	2,713,128.50
210204	Ажилгүйдлийн даатгал	844,031.03	2,713,129.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,439,734.45	10,852,614.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	13,300,962.21	26,052,584.69
210301	Гэрэл, цахилгаан	2,022,476.00	5,154,593.45
210302	Түлш, халаалт	9,133,696.21	18,875,291.24
210303	Цэвэр, бохир ус	2,144,790.00	2,022,700.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	19,585,320.31	22,132,272.00
210401	Бичиг хэрэг	3,719,200.00	4,401,650.00
210402	Тээвэр, шатахуун	12,109,200.00	13,817,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,303,620.31	2,509,530.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	566,792.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	853,300.00	837,100.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	9,639,900.00	17,257,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	800,000.00	3,072,000.00
210604	Урсгал засвар	8,839,900.00	14,185,200.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	7,216,300.00	13,960,700.00
210702	Дотоод албан томилолт	7,216,300.00	13,960,700.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	217,725,800.00	177,800,153.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	210,841,473.00	171,386,355.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	247,100.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	604,792.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,784,000.00	6,054,000.00
210807	Газрын төлбөр	1,238,435.00	359,798.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,155,000.00	1,349,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,155,000.00	1,349,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>26,518,130.71</b>	<b>141,256,547.31</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,450,000.00	91,662,606.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	5,400,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	84,612,606.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,450,000.00	1,650,000.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	25,068,130.71	49,593,941.31
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	6,657,462.00	11,301,382.00
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	18,410,668.71	38,292,559.31
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>11,763,000.00</b>	<b>9,428,000.00</b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>11,763,000.00</b>	<b>9,428,000.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>11,763,000.00</b>	<b>9,428,000.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	11,763,000.00	9,428,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,763,000.00	9,428,000.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(11,763,000.00)</b>	<b>(9,428,000.00)</b>
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	=	=
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	330,634,074.85	85,813,397.90	164,314,044.68	580,761,517.43
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	330,634,074.85	85,813,397.90	164,314,044.68	580,761,517.43
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	321,647,983.43	321,647,983.43
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	330,634,074.85	85,813,397.90	485,962,028.11	902,409,500.86
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	330,634,074.85	85,813,397.90	485,962,028.11	902,409,500.86
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	330,634,074.85	85,813,397.90	485,962,028.11	902,409,500.86
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	793,445,593.87	793,445,593.87
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	330,634,074.85	85,813,397.90	1,279,407,621.97	1,695,855,094.72

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,005,253,100.00	958,901,440.69	46,351,659.31	95.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,005,253,100.00	958,901,440.69	46,351,659.31	95.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	883,690,100.00	867,238,834.69	16,451,265.31	98.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	571,546,800.00	568,045,354.00	3,501,446.00	99.39
210101	Үндсэн цалин	366,442,100.00	346,823,019.00	19,619,081.00	94.65
210102	Нэмэгдэл	149,227,000.00	163,031,041.00	(13,804,041.00)	109.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,193,300.00	30,420,262.00	(3,226,962.00)	111.87
210104	Урамшуулал	28,684,400.00	27,771,032.00	913,368.00	96.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,416,200.00	73,335,931.00	80,269.00	99.89
210201	Тэтгэврийн даатгал	51,953,700.00	51,873,431.00	80,269.00	99.85
210202	Тэтгэмжийн даатгал	5,365,600.00	5,365,600.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,682,800.00	2,682,800.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,682,800.00	2,682,800.00	-	100.00

210205	Эрүүл мэндийн даатгал	10,731,300.00	10,731,300.00	-	100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	26,083,400.00	26,052,584.69	30,815.31	99.88
210301	Гэрэл, цахилгаан	5,156,000.00	5,154,593.45	1,406.55	99.97
210302	Түлш, халаалт	18,904,700.00	18,875,291.24	29,408.76	99.84
210303	Цэвэр, бохир ус	2,022,700.00	2,022,700.00	-	100.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	22,172,600.00	22,132,272.00	40,328.00	99.82
210401	Бичиг хэрэг	4,401,700.00	4,401,650.00	50.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	13,817,200.00	13,817,200.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,528,000.00	2,509,530.00	18,470.00	99.27
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	588,600.00	566,792.00	21,808.00	96.29
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	837,100.00	837,100.00	-	100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	26,685,200.00	26,685,200.00	-	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,500,000.00	12,500,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	14,185,200.00	14,185,200.00	-	100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	17,827,100.00	13,730,700.00	4,096,400.00	77.02
210702	Дотоод албан томилолт	17,827,100.00	13,730,700.00	4,096,400.00	77.02
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	144,455,700.00	135,907,793.00	8,547,907.00	94.08
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	138,041,900.00	129,493,995.00	8,547,905.00	93.81
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,054,000.00	6,054,000.00	-	100.00
210807	Газрын төлбөр	359,800.00	359,798.00	2.00	100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,503,100.00	1,349,000.00	154,100.00	89.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,503,100.00	1,349,000.00	154,100.00	89.75
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	121,563,000.00	91,662,606.00	29,900,394.00	75.40
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	121,563,000.00	91,662,606.00	29,900,394.00	75.40
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,400,000.00	5,400,000.00	-	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,995,500.00	-	16,995,500.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	97,509,100.00	84,612,606.00	12,896,494.00	86.77
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,658,400.00	1,650,000.00	8,400.00	99.49
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,005,253,100.00	958,901,440.69	46,351,659.31	95.39
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,005,253,100.00	958,901,440.69	46,351,659.31	95.39
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,005,253,100.00	958,901,440.69	46,351,659.31	95.39
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	24	24	-	100.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1	-	100.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	24	24	-	100.00
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	19	19	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	4	4	-	100.00

## 2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>77,393,371.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>77,393,371.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>77,393,371.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>22,848,991.00</b>

210101	Үндсэн цалин	15,715,701.00
210102	Нэмэгдэл	7,133,290.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>12,422,020.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	3,026,873.50
210202	Тэтгэмжийн даатгал	9,213,175.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	30,328.50
210204	Ажилгүйдлийн даатгал	30,329.00
210205	Эрүүл мэндийн даатгал	121,314.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>230,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	230,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>41,892,360.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41,892,360.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>77,393,868.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>77,393,868.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	74,071,508.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,522,360.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	800,000.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь "Хүнс, хөдөө аж ахуйн салбарын талаарх төр, засгийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг оновчтой зохион байгуулж, аж ахуйн нэгж, байгууллага, малчид, тариаланчид, иргэдийг мэдээ, мэдээлэл, мэргэжил, арга зүй, технологийн удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай, шуурхай хүргэж, орон нутгийн болон салбарын түвшинд дэвшүүлсэн бодлогыг хэрэгжүүлэх замаар түүхий эдийн нөөцийг зохистой ашиглах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн салбарын эдийн засгийн өсөлтийг тогтвортой нэмэгдүүлэх зорилгод хүрэх" эрхэм зорилготой тус байгууллага нь 2024 онд 24 орон тоотой үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг дарга У.Балжинням 2024.01.01-2024.04.15, 2024.11.13-2024.12.31 хүртэлх хугацаанд, даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнхтогтох 2024.04.24-2024.11.13 хугацаанд, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Т.Уянга нар зурж, нярваар З.Амарсүрэн нар ажиллажээ.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай, Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай, Малчны тухай, Малчин ерхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай, Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай, Гэрийн тэжээвэр амьтны тухай, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай,

Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үргэлжлүүлэн мөрдсөн;
- Засгийн газрын тогтоолоор албан хаагчдын цалин нэмэгдсэн;
- ТБОНӨХБАҮХАТХ-ийн шинэчилсэн найруулгыг 2023.06.16-ны өдөр баталж, 2024.01.01-ний өдрөөс эхлэн мөрдсөн;
- Сангийн сайдын 2024 оны 2024 оны 229, А/211 дугаар тушаалаар Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, төсвийн эдийн засгийн ангилал, санхүүгийн байдлын тайлангийн дансны жагсаалтыг шинэчлэн баталсан.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/32 тоот тушаалаар Байгууллагын дотоод хяналт шалгалтын журмыг баталсны дагуу 2024 онд Дотоод, хяналт шалгалт хийх 2024 оны ажлын төлөвлөгөөг дөрвөн чиглэлээр гүйцэтгэсэн байгаа тул дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хуулийн дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 781,139.1 мянган төгрөгөөр буюу 186.6 хувиар нэмэгдсэн байна.  
Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	2,827.0	99.2	(2,727.8)
Бараа материал	278,707.8	298,092.7	19,384.8
Үндсэн хөрөнгө	982,300.7	1,963,998.4	981,697.7
Хуримтлагдсан элэгдэл	(361,426.1)	(578,641.7)	(217,215.6)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>902,409.5</b>	<b>1,683,548.6</b>	<b>781,139.1</b>

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	902,409.5	1,683,548.6	781,139.1
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>902,409.5</b>	<b>1,683,548.6</b>	<b>781,139.1</b>

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан данс нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Өмнөх аудитаар санхүүгийн тайланд бүртгэлтэй хувь хүнээс авах 2,827.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулах зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн, авлагыг бүрэн барагдуулсан ба тайлант онд нийгмийн даатгалын шимтгэлийн 79.2 мянган төгрөгийн авлагатай гарсан ба аудитаар 20.0 мянган төгрөгийн авлагыг залруулсан.

Бараа материалын оны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 19,384.8 мянган төгрөгөөр нэмэгдэж 310,399.2 мянган төгрөг болсон нь тайлант онд ХХААЯ-аас баланс хоорондын шилжүүлгээр 78,792.5 мянган төгрөгийн ногооны үр, 176,000.0 мянган төгрөгийн бактобромдиолоны бэлдмэл үнэ төлбөргүй авч, сумдад 195,500.1 мянган төгрөгийн материал олгосонтой холбоотой ба аудитаар 12,306.5 мянган төгрөгийн услалтын системийг ашиглагч байгууллагад шилжүүлэн залруулга хийсэн.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үндсэн хөрөнгө өмнөх оноос 981,697.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, 1,963,998.4 мянган төгрөг болсон нь төсвийн хөрөнгөөр 9,438.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, ХХААЯ-аас 120,003.7 мянган төгрөгийн Тоёота ланд круйзер 200 суудлын автомашиныг баланс хоорондын шилжүүлгээр авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 781,139.1 мянган төгрөгөөр нэмэгдэн Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,683,548.6 мянган төгрөг болсон байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант оны улсын төсвөөс олгох санхүүжилтийг 882,271.3 мянган төгрөгөөр төсөвлөснөөс эрх бүхий дээд газраас байр ашиглалттай холбоот

ой тогтмол зардал, хангам, бараа материалын зардал, томилолтын зардлыг бууруулан, анхны төсвийг 725,825.5 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Анхны баталсан төсвийн хуваарьт 4 дүгээр сард 11,000.0 мянга, 9 дүгээр сард 279,427.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн өөрчлөлт оруулж, нийт төсвийг 1,005.253.1 мянган төгрөгийн санхүүжилтээр баталжээ.

Баталсан санхүүжилтээс тайлант онд 11,236.1 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу буюу 994,017.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд нийт зардлын 96.2 хувийг буюу 955,724.4 мянган төгрөгийг зарцуулан оны эцэст зардлын хэмнэлтийн 38,292.6 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл (мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
70,801	Мал аж ахуйг хөгжүүлэх	100,580.00	99,700.00	880.00	99.13
82,517	Үлийн цагаан оготной тэмцэх	47,400.00	46,520.00	880.00	98.14
82,542	Монгол мал хөтөлбөр	53,180.00	53,180.00	-	100.00
70,803	Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх	25,056.90	17,389.00	7,667.91	69.40
80,101	Үндсэн үйл ажиллагааны зардал	25,056.90	17,389.00	7,667.91	69.40
70,805	Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого удирдлага	879,616.20	841,812.45	37,803.75	95.70

80,802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	121,563.00	91,662.61	29,900.39	75.40
	ДҮН	1,005,253.10	958,901.44	46,351.66	95.39

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын төсвийн хэлбэлзэл

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар орон нутгийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр төрийн захиргааны албан хаагчдын орон нутгийн нэмэгдэлд олгох санхүүжилтийн 35,271.5 мянга, орон нутгийн төсвөөс малд шилэн сонголт хийх, зохиомол хээлтүүлэг хийх зардалд 38,800.0 мянган төгрөгийг олгож, ХХААЯ-наас ЖДҮХС-ийн хяналтын зардалд 2,522.4 мянган төгрөгийг олгож, “Усаа нөөцлө” уралдааны 2 дугаар байрын шагналд 800.0 мянга, нийт 77,393.4 мянган төгрөг орсныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Мөн байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар ХХААЯ-аас үнэ төлбөргүй олгосон хүнсний ногооны үрийг 80 хувийн хөнгөлөлттэй үнээр борлуулан, үнийн 20 хувь буюу 11,300.9 мянган төгрөгийг дансанд оруулсныг оны эцэст төсөвт төвлөрүүлжээ.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд 28,000.0 мянган төгрөгийн бог малын өсвөрийн хээлтүүлэгч сонгон шалгаруулах тендер, 26,400.0 мянган төгрөгийн баталгаажсан үүлдэр омгийн малд шилэн сонголт хийх тендерийг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан тендерийг зарлаж, үр дүнг мэдээлсэн байна.

Дээрх тендерүүдэд шалгарсан “Залаагийн цагаан сувд” ХХК, “Мандаа торгон сүрэг” ХХК-тай байгууллагын удирдлага гэрээ байгуулж, худалдан авалтыг нягтлан бодох бүртгэлд зардлаар тайлагнасан ба аудитын явцад аж ахуйн нэгжүүдтэй баталгаажуулах тулгалтыг хийсэн болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан, холбогдох баримт, материалыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр 1/21 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант жилийн

батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлж, материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталсан төсвийн 1,005,253.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 10,052.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 60 хувиар буюу 6,031.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурийг нийт хөрөнгийн 1,683,548.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 16,835.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 60 хувиар буюу 10,101.3 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагад завсрын аудитыг гүйцэтгээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Батчимэг гүйцэтгэж, "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн ба аудитаар тогтоосон 2 төлбөрийн акт, өгсөн 1 зөвлөмж, 1 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	1,210.5	2	1,210.5	100
Албан шаардлага	1	114,699.4	1	114,699.4	100
Зөвлөмж	1	2,827.0	1	2,827.0	100
Залруулга	2	56,478.0	2	56,478.0	100
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>175,214.9</b>	<b>6</b>	<b>175,214.9</b>	<b>100</b>

Эх сурвалж: ТАГ-ын санхүүгийн тайлангийн FAS систем

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагын 2024 оны санхүүгийн тайланд Төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацаанд аудит хийхэд хугацаа богино оногдож байгаагаас аудитаар зарим асуудлыг тодруулж, дараагийн аудитад дараах асуудлуудад анхаарах нь зүйтэй гэж аудитор үзэж байна. Үүнд:

- Баянхонгор аймгийн ХХААГ-ын санхүүгийн тайланд бүртгэлтэй, ХХААХҮЯ-аас 2018 онд нийлүүлсэн 20,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий ямааны саалтуурыг ямааны эрчимжсэн аж ахуй байхгүй шалтгаанаар ашиглаагүй байгаа тул эрх бүхий байгууллагад асуудлыг тавьж, хэрэгцээтэй байгууллагад шилжүүлэн төсвийн хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх;
- Санхүүгийн тайланд бүртгэлтэй 2023 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжсэн 38,000.0 мянган төгрөгийн дуслын услалтын системийг жимсгэний платацид байрлуулсан асуудлыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2025 онд гүйцэтгэх “Улс, орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт” гүйцэтгэлийн аудитаар тодруулах шалгах нь зүйтэй байна.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 15,503.5 мянган төгрөгийн 3 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад авлага, бараа материал, төсвийн гүйцэтгэлийн тайланд алдааг залруулав.

Залруулсан алдаа:

1. Тайлант онд байгууллагын удирдлага “Мандаа торгон сүрэг” ХХК-тай 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдөр гэрээ байгуулж, Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох ажлыг 26,400.0 мянган төгрөгөөр гүйцэтгэхээр заасан байхад гүйцэтгэлээр 26,420.0 мянган төгрөгийг олгож, 20,0 мянган төгрөгийг гэрээний дүнгээс илүү олгосон атлаа санхүүгийн тайланд зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэснийг зөрчсөн тул санхүүгийн тайланд авлагыг нэмэгдүүлсэн;
2. Санхүүгийн тайланд бүртгэлтэй 12,306.5 мянган төгрөгийн дуслын усалгааны системийг “Баянхонгор Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ ашиглаж байхад нягтлан бодох бүртгэлээс хасаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэснийг зөрчсөн тул байгууллагын бараа материалаас хасаж, ашиглаж байгаа байгууллагад шилжүүлэн залруулсан;
3. Төсвийн гүйцэтгэлийн тайланд өмнөх оны барагдуулсан авлагын 2,827.0 мянга, тендерийн баримт бичгийн орлогын 350.0 мянга, нийт 3,177.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: Үнэн зөв байх” гэснийг зөрчсөн тул төсвийн гүйцэтгэлийн тайлангийн орлогыг бууруулан залруулав.

Аудитаар нийт 17,096.0 мянган төгрөгийн 2 зөрчил<sup>2</sup> илэрснээс, зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлсэн.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Аудитаар илрүүлсэн материаллаг алдаагаар тооцсон зөрчлийн дүн 9,896.0 мянган төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

1. Төсөвт байгууллагууд Сангийн яамны Төсвийн төлөвлөлтийн программыг үйл ажиллагаандаа үнэ төлбөргүйгээр ашиглаж байхад тус байгууллагын дарга “Даталанд технологи” ХХК-тай 2024 онд гэрээ байгуулан 7,200.0 мянган төгрөгөөр тусдаа төсвийн нэгдсэн системийн программ авч үргүй зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн яамны Төсвийн төлөвлөлтийн системийг ашиглан санхүүгийн үйл ажиллагааг явуулж, дээрх үнэ төлбөртэй системийг ашиглахыг зогсоох албан шаардлагыг өглөө.

2. Байгууллагын бараа материалын дансанд өмнөх онуудад сумдад олгосон 9,896.0 мянган төгрөгийн 35 ширхэг 1 тонны усны сав үлдэгдлээр байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалыг сумдад олгосон санхүүгийн баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэлээс хасах албан шаардлагыг хүргүүлэв.

Аудитаар өгсөн албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтанд талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төсвийн гүйцэтгэлийн тайланд өмнөх оны барагдуулсан авлагын 2,827.0 мянга, тендерийн баримт бичгийн орлогын 350.0 мянга, нийт 3,177.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор тайлагнасан.	1	3,177.0			1	3,177.0	1	3,177.0				
Санхүүгийн тайланд бүртгэлтэй 12,306.5 мянган төгрөгийн дуслын усалгааны системийг Баянхонгор Төхижилт үйлчилгээ ОНӨААТҮГ ашиглаж байхад нягтлан бодох бүртгэлээс хасаагүй байна.	1	12,306.5			1	12,306.5	1	12,306.5				
Тайлант онд байгууллагын удирдлага “Мандаа торгон сүрэг” ХХК-тай 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдөр гэрээ байгуулж, Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох ажлыг 26,400.0 мянган төгрөгөөр гүйцэтгэхээр заасан байхад гүйцэтгэлээр 26,420.0 мянган төгрөгийг олгож, 20.0 мянган төгрөгийг гэрээний дүнгээс илүү олгосон	1	20.0	1	20.0			1	20.0				
<b>ДҮН</b>	<b>3</b>	<b>15,503.5</b>	<b>1</b>	<b>20.0</b>	<b>2</b>	<b>15,483.5</b>	<b>3</b>	<b>15,503.5</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)**

Зөрчлийн товч утга	Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Байгууллагын дарга "Даталанд технологи" ХХК-тай 2024 онд гэрээ байгуулан, төсвийн нэгдсэн системийн программ хангамж болох <a href="https://www.mofa.opengov.mn">https://www.mofa.opengov.mn</a> системийг нийлүүлж, системийн сарын төлбөр 600.0 мянга, жилд 7,200.0 мянган төгрөг төлснийг төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан ба тус байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж байгаа санхүүгийн программын жилийн төлбөр жилд 600.0 мянган төгрөг байгаатай харьцуулахад төлбөр өндөр, хэрэглээ багатай гэж үзэхээр байна.	1	7,200.0			1	7,200.0						
Байгууллагын аж ахуйн дансанд бүртгэлтэй 9,896.0 мянган төгрөгийн 35 ширхэг 1 тонны усны савыг өмнөх жилүүдэд сумдад олгосон байхад нягтлан бодох бүртгэлд зардлаар бүртгээгүй байна.	1	9,896.0			1	9,896.0						
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>17,096.00</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>17,096.00</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

---oOo---